



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/792

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а” заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч Бүгд найрамдах Хятад ард улсад айлчлахдаа коронавирусийн /сovid-19/ цар тахалтай тэмцэх үйлсэд дэмжлэг үзүүлэх үүднээс 30 мянган толгой хонийг хандив болгон хүргүүлэхээр болсонтой холбогдуулан энэхүү ажлыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн сумдаас ирүүлэх хандивын хонийг татан бөөгнөрүүлэх, хүлээн авах ажлыг зохион байгуулах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Т.Жаргалсайхан - Аймгийн Засаг даргын орлогч

Ажлын хэсгийн

гишүүд: Ч.Багдал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Б.Бямбажав - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Д.Эрдэнэдорж - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэр, худалдаа үйлчилгээний албаны дарга

Б.Хашбат - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хөдөө аж ахуйн хяналтын улсын байцаагч

С.Шурхүү - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албаны цөм сүрэг хариуцсан мэргэжилтэн


Нарийн бичгийн

дарга: Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Zax A/792 Ch

02 3614

2. Шаардлагатай тохиолдолд бусад холбогдох байгууллагуудыг татан оролцуулах, мэдээ мэдээллийг тухай бүр ирүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ